



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Г.Ууганбаярт сахилгын шийтгэл
ногдуулах тухай


Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 37.1.15, 48 дугаар зүйлийн 48.1.2, Нийслэлийн Засаг Даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Гантөмөрийн Ууганбаяр нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэгтээ хариуцлагагүй хандаж, удирдлагаас өгсөн цаг үеийн чанартай үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй тул албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Г.Ууганбаярт ногдуулсан сахилгын шийтгэлийг 2019 оны 05 дугаар сарын 01-нээс тооцож, цалин олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Цаашид ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, хариуцлагатай ажиллахыг Г.Ууганбаярт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Гантөмөрийн Ууганбаярт мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

